

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2021.1.25-2021.02.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын харьяалалгүй ахмад настнуудыг аж ахуйн нэгж байгууллагад харьяалуулах ажлыг зохион байгуулж Сумын хэмжээнд нийт 296 ахмад настнаас 251 ахмад настан буюу 84,8 хувийг суманд үйл ажиллагаа явуулдаг 40 аж ахуйн нэгж, байгууллагад харьяалуулж, харьяалалгүй 45 ахмад настныг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хүндэтгэлд хамруулаад байна. Сумын шуурхай штабаас Улаанбаатар хот болон өөр аймаг орон нутаг руу зорчих зөвшөөрлийг зөвшөөрөгдсөн 4 шалтгаанаар өссөн дүнгээр 117 иргэнд олгоод байна.

Сум руу ирэх хүсэлт гаргасан 24 иргэнийг 2021 оны 2-р сарын 25-ний өдрийн байдлаар гэрийн тусгаарлалтанд 24 иргэн байна. Түргэвчилсэн оношлуураар өссөн дүнгээр 5, PCR шинжилгээнд 22 иргэнийг тус тус хамруулсан байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ :

1. БСУГ-аас сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтнуудад:

- I. Цахим болон зайн сургалтын чанар үр дүн
- II. Элсэлтийн нэгдсэн шалгалтад 12-р ангийг бэлтгэх, өмнөх улирлын хоцрогдлыг хэрхэн нөхөх,
- III. Боловсролын стратеги төлөвлөгөө боловсруулах зэрэг асуудлаар хэлэлцүүлэг хийлээ.

2. I улирлын хоцрогдлыг аймаг сумын хэмжээнд арилгах, II улирлын агуулгыг ямар арга зүйгээр судлах зэрэг арга туршлагаа онлайн хэлбэрээр захирлууд, мэргэжлийн

багийн ахлагч нар хамрагдсан хэлэлцүүлэг хийлээ. Үүнд захирал, сургалтын менежрүүд оролцлоо.

3. Багш, ажилтан ажилчдын эрүүл мэндийг дэмжиж гэртээ дасгал хөдөлгөөн хийх, ажлын байран дээр 6-аас дээшгүй хүн дасгал хөдөлгөөн хийж байна.



4. Сургуулийн дотуур байр, спорт заал, багш хөгжлийн төвийн сантехникийн засвар хийгдлээ.

5. Сар шинийн өмнө сумын төвийн хуваарьт талбай, байгууллагын эргэн тойрон 100 метр талбайд их цэвэрлэгээ хийлээ.



6. Шинийн 2-нд аюулт цар тахлаас сэргийлж төрийн албан хаагчдыг хариуцлагатай эргүүлээр байгууллага болон суманд гаргасан. Гаргасан хуваарийн дагуу үүргээ ухамсарлан сэтгэл гарган хариуцлагатай ажиллаа.



7. Цахимаар хамт олны хурал хийж I улирлын хоцрогдол нөхөх, II улирлын агуулгыг төлөвлөх цахимаар заах бэлтгэл хийх, зорилтот бүлэг болон малчдын хүүхдэд зайн сургалт зохион байгуулах аргаа сонгох, теле хичээлийг үзэхэд хяналт тавих, хүүхэд эцэг эхэд анхааруулга зөвлөмж хүргэх, сургуулийн давтлагын хуваарийн дагуу цахимаар давтлага өгөх зэрэг асуудлыг мэдээллээ.



8. Байгууллагын 23 ахмад настанд хүндэтгэл үзүүлж дархлаажуулалт хийж, мөнгөн тусламж өглөө.

9. Улирал эхэлснээс хойш теле хичээлийн бие даалт хийхгүй байгаа 11-р ангийн 7 сурагчидтай утсаар холбогдож зөвлөгөө өглөө.

10. 2 сараас 12-р ангийн давтлага орох магадлалтай байгаа учраас давтлагын анги танхим бэлтгэх, ариутгах, зай барих тэмдэг байрлуулах, халуун хэмжигч, гар ариутгагч бэлтгэх, суудлын зураглал гаргах зэрэг бэлтгэлийг хийлээ.

11. 2021 оны 02-о сарын 1, 2-нд 12А,Б ангийн 32 сурагчийг эцэг эхтэй нь сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан элсэлтийн нэгдсэн шалгалтын багш нар цагийн хуваариар хүлээн авч уулзлаа. Гол зорилго нь уулзалтын гурвалсан гэрээгээ дүгнэж, элсэлтийн нэгдсэн шалгалтын бэлтгэл хир байгаа, эцсийн байдлаар суралцагч ямар мэргэжилтэй болох, ямар ямар хичээлээр шалгалт өгөх дээр тогтон ярилцаж шалгалтандаа хэрхэн бэлтгэх талаар зөвлөгөө өглөө. Энэ үйл ажиллагаанд эцэг эх болон багш суралцагчийн сэтгэл ханамж маш өндөр, цаг үеэ олсон үйл ажиллагаа байсанд талархаж байлаа.

СӨБ-н үйл ажиллагаа


1. Хамран сургалт.


| д/д | Бүлэг | Бүлгийн хүүхдийн хүүхдийн тоо | Теле хичээл үзэх хүүхдийн тоо | Багштай харилцаж теле хичээл үзэж байгаа хүүхдийн тоо | Өдрийн дундаж ирц | Хувь |
|-----------------|---------------|-------------------------------|-------------------------------|---|-------------------|-------|
| 1 | Бага бүлэг | 26 | 26 | 21 | 21 | 79% |
| 2 | Дунд бүлэг | 98 | 98 | 88 | 88 | 88,7% |
| 3 | Ахлах бүлэг | 86 | 86 | 74 | 74 | 86,0 |
| 4 | Бэлтгэл бүлэг | 78 | 78 | 69 | 69 | 85,3 |
| Цэцэрлэгийн дүн | | 288 | 288 | | 252 | 87,5% |

Багш бүр теле хичээл үзүүлэх болон цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарын авлага ном тараах, өөрсдийн бэлтгэсэн хичээлийн бүлэг бүрийн групп хуудасаар дамжуулан хүргэж байгаа нь нийт хүүхдийн 87.5 % ийг хамруулаад байна.

2. Сургалтын ажил.

Хөл хорио тогтоосонтой холбогдуулан тус цэцэрлэгийн багш нар бүлэг бүрийн нүүр хуудсаараа дамжуулан ЗАН-ээрээ болон бие даан хийсэн цахим сургалтын хэрэглэгдэхүүн, эрүүл ахуй, аюулгүй байдлын зөвлөмж зөвлөгөөг түгээж байна.





1. Одоогийн байдлаар тус цэцэрлэгийн ЗАН-ийн цахим санд нийт 50 гаруй сургалтын цахим хэрэглэгдэхүүний нөөцтэй байна. Цахим сургалтын хамрагдал 90%-тай байна. Бага, Дунд бүлэг гэр бүл сэдэв, Ахлах бүлэг Шагай, Бэлтгэл бүлэг Үндэсний хувцас сэдвийн хүрээн цахим сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан теле болон цахим хичээл, даалгаврын ном боловсуулан бэлтгэн түгээж сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган ажиллаж байна. Мөн эрүүл ахуй, осол аюулгүй зөвлөмж, зөвлөгөөг тогтмол оруулан даалгаврын буцаан ирүүлэлтэнд дүгнэлт хийн ажиллаж байна



Мөн ГСА-ийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын сургалтын агуулгын хоцрогдолыг нөхөн олгох үйл ажиллагаанд тус цэцэрлэгийн арга зүйч, багш нар оролцож байна. Үүнд:

Дунд бүлгийн багш Ц.Батчимэг, С.Эрдэнэчимэг, А.Рэгзэдмаа нар, Ахлах бүлгийн багш Г.Амарсайхан, Г.Анхмаа, Б.Бархүү нар хөдөлгөөн эрүүл мэнд, Бага бүлгийн багш Ц.Мягмартуяа, Бэлтгэл бүлгийн багш Ц.Баярмаа, Л.Наранчимэг нар математикийн энгийн төсөөлөл сургалтын чиглэлийн дагуу тус тус цахим болон теле хичээл бэлтгэн аймгийн хэмжээнд түгээж байна. арга зүйч Ц.Туул аймгийн

хэмжээнд Бэлтгэл бүлгийн багш нарыг зохион байгуулан агуулгын хоцрогдолыг нөхөх сургалтын үйл ажиллагааг явуулж байна. Нийт 10 багш оролцон сургалтын чиглэл бүрээр багш бүр цахим сургалт явуулан даалгаврын ном боловсуулан хүүхдүүдэд түгээн ажиллаж байна.


3.Багшийн хөгжил.

Тогооч нарын сургалт 2-р сарын 1-10-ны хооронд явагдсан “Эмчилгээний хоол-Хүүхдийн хоол тэжээл” сэдэвт цахим сургалтанд тогооч Э.Сарангэрэл, Г.Мөнхнасан нар хамрагдсан.



**2021.02.01-с эхлэх
эмчилгээний хоол,
хүүхдийн хоолны
онлайн
сургалтандаа
бүртгэж байна.**

- 2-р сарын 19-ний өдөр “Ур чадварын нэмэгдэл олгох журам” сэдвээр нийт багш ажилчдын дунд зохион явуулж, мэдээлэл өгсөн.



- 1-р сарын 29-нд арга зүйч Ц.Туул “Сүүдрийн театр”-ийн талаар сургалтыг туслах багш нарт явуулж, туслах багш нар туршлага солилцож хамтарч ажилласан.




Нийтийг хамарсан ажил

- Сумын нийтийн их цэвэрлэгээнд 2 удаа хамрагдаж, сумын төв талбайн цэвэрлэгээ болон байгууллагын орчны цэвэрлэгээг хийж ажилласан.




- Сар шинийн өдрүүдэд (2-р сарын 11-14) цэцэрлэг дээр хариуцлагатай жижүүрийг батлагдсан хуваарийн дагуу ажиллуулсан.


БАТЛАВ.ЭРХЛЭГЧ  Б.ДАВААДОЛГОР
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН III ЦЭЦЭРЛЭГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ
2020 оны 2 дугаар сарын 11-14-ний өдрүүд

| № | Эцгийн болон өөрийн нэр | Албан тушаал | Хуваарь өдөр | Хугацаа | Утасны дугаар |
|---|---------------------------|--------------|--------------|------------------------------------|---------------|
| 1 | Цэгмидийн Баярмаа | Бүлгийн багш | 2021-02-11 | 09 ⁰⁰ -14 ⁰⁰ | 89121269 |
| 2 | Аюурын Рэгээдмаа | Бүлгийн багш | 2021-02-11 | 14 ⁰⁰ -18 ⁰⁰ | 95549479 |
| 3 | Цогтбаярын Мягмартуяа | Бүлгийн багш | 2021-02-12 | 09 ⁰⁰ -14 ⁰⁰ | 88720342 |
| 4 | Болдмаагийн Бархүү | Бүлгийн багш | 2021-02-12 | 14 ⁰⁰ -18 ⁰⁰ | 80770299 |
| 5 | Цэрэн-Очирын Батчимэг | Бүлгийн багш | 2021-02-13 | 09 ⁰⁰ -14 ⁰⁰ | 99696189 |
| 6 | Галбатын Анхмаа | Бүлгийн багш | 2021-02-13 | 14 ⁰⁰ -18 ⁰⁰ | 99550578 |
| 7 | Гунгаанамжилын Амарсайхан | Бүлгийн багш | 2021-02-14 | 09 ⁰⁰ -13 ⁰⁰ | 89986480 |
| 8 | Самбуугийн Эрдэнэчимэг | Бүлгийн багш | 2021-02-14 | 13 ⁰⁰ -17 ⁰⁰ | 90113488 |
| 9 | Жигмэдсүрэнгийн Оюунчимэг | Бүлгийн багш | 2021-02-14 | 17 ⁰⁰ -21 ⁰⁰ | 95109028 |

Тайлбар: Хариуцлагатай жижүүр хийх хугацаандаа байгууллагын манаач нарт хяналт тавин мэдээлэл авч холбогдох мэдээлэлийг сумын онцгой комиссын 70546386 дугаарын утсанд өгнө.

Жижүүрийн хуваарь хийсэн: Арга зүйч  Ц.Туул

- Байгууллагын цахим хурлыг 2-р сарын 17-ны өдөр 86%-ийн ирцтэй зохион байгуулж “Орчин цагийн боловсролын 100 жилийн ой”-г угтан хийх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг болон “Мод тарих” ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг тус тус ТОМИЛСОН.



- Байгууллагын харъяат ахмадуудад сар шинийн хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж, 10 ахмад настанд тус бүр 300.000 төгрөгийг өгсөн.



Сумын эргүүл, постын ажил

- Сумын шуурхай штабаас гаргасан хуваарийн дагуу штабын жижүүрт 4 удаа гарсан

| | | | | | |
|----|-----------------|---------------|---|------------|----------|
| 15 | Мэргэжлийн анги | Э.Сарангэрэл | 3-р цэцэрлэгийн багш | 2021.02.06 | 94929296 |
| 16 | Мэргэжлийн анги | С.Номинзул | ЕБСургуулийн Монгол хэл, уран зохиолын багш | 2021.02.07 | 96146838 |
| 17 | Мэргэжлийн анги | Б.Ариунаа | ШОХК-ийн ХАБЭАХ-ийн эзлжийн инженер | 2021.02.08 | 99149596 |
| 18 | Мэргэжлийн анги | Д.Ууганбат | ЭМТөвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан | 2021.02.09 | 99077960 |
| 19 | Мэргэжлийн анги | С.Энх-Амгалан | Илчлэг Шивээ ОНӨҮГ-ын Бичиг хэрэг | 2021.02.10 | 90901540 |
| 20 | Мэргэжлийн анги | А.Амархүү | БЗӨБЦТС-ТӨХК-ийн Говьсүмбэр салбарын Шивээговь хэсгийн монтёр | 2021.02.11 | 99056670 |
| 21 | Мэргэжлийн анги | Д.Эрдэнэтулга | ЗДТГ-ын ХААТ-ийн мэргэжилтэн | 2021.02.12 | 99025054 |
| 22 | Мэргэжлийн анги | Э.Жаргалмаа | ЕБСургуулийн Химийн багш | 2021.02.13 | 99973544 |
| 23 | Мэргэжлийн анги | Ж.Оюунгэрэл | Соёлын төвийн дуучин | 2021.02.14 | 86961676 |
| 24 | Мэргэжлийн анги | О.Отгонбаяр | ЗДТГ-ын Байгаль хамгаалагч | 2021.02.15 | 86133909 |
| 25 | Мэргэжлийн анги | Ц.Баярмаа | 3-р цэцэрлэгийн багш | 2021.02.16 | 89121269 |
| 26 | Мэргэжлийн анги | Л.Цэцэгсайхан | Шивээ Сервис ХХК-ийн ажилтан | 2021.02.17 | 99054320 |
| 27 | Мэргэжлийн анги | Б.Энх-Амгалан | ШОХК-ийн ХАБЭАХ-ийн эзлжийн инженер | 2021.02.18 | 95232590 |
| 28 | Мэргэжлийн анги | А.Аюурхүү | ЕБС-ийн Номын санч | 2021.02.19 | 88050879 |
| 29 | Мэргэжлийн анги | Ц.Туул | 3-р цэцэрлэгийн Арга зүйч багш | 2021.02.20 | 99017689 |
| 30 | Мэргэжлийн анги | Б.Энхмаа | ЗДТГ-ын ХААТ-ийн мэргэжилтэн | 2021.02.21 | 99824854 |
| 31 | Мэргэжлийн анги | Г.Бум-Аюуш | ЭМТ-ийн нягтлан бодогч | 2021.02.22 | 88504031 |
| 32 | Мэргэжлийн анги | Ш.Юмжирдулам | Илчлэг Шивээ ОНӨҮГ-ын байцаагч | 2021.02.23 | 90117116 |
| 33 | Мэргэжлийн анги | Ц.Пүрэвням | 3-р цэцэрлэгийн нягтлан бодогч | 2021.02.24 | 80808002 |

- Сар шинийн баяраар сумын хэмжээнд тэг зогсолт хийж 2-р сарын 14-ний өдөр буюу шинийн 3-ны өдөр нийт 22 багш ажилтан Цагдаагийн хэсгээс өгсөн чиглэлийн дагуу 9:00-21:00 цагийн хооронд сумын 1-р багийн нутаг дэвсгэрт эргүүл хийж ажилласан.





- 2-р сард төв замын постонд 3 удаа хоол хийж хүргэж өгсөн.
- Байгууллагын дарга нарын эргүүлд 2 удаа гарсан.

Санхүү бүртгэлийн ажил.

Төрийн аудитаас 2020 оны цэцэрлэгийн санхүүгийн баримтад аудит хийлгэхээр ээлтгэж байна. 2020 оны жилийн эцэсийн хөрөнгийн тооллого хийгдсэн. 2020 оны жилийн эцэсээр өр авлага үүсээгүй.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

- Амбулаторийн үзлэг -484 томуу-10
- Урьдчилан сэргийлэх – 0
- Дуудлага-143
- Эмнэлэгт хэвтсэн- 14
- PCR шинжилгээ-67

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материалын хүрэлцээтэй байна. Эм тарианы хангалт хүрэлцээтэй байна.

02 сарын 09-ний өдөр сумын төвд байгууллагад ноогдсон талбайд их цэвэрлэгээг хийж ажилласан.




02 сарын 11-ний байгууллагын 17 ахмадад хүндэтгэл үзүүлж гарын бэлэг өгсөн байна.



01 сарын 27- эхлэн халдварт САА-с сэргийлэх нөхөн дархлаажуулалтыг 2-5 насны 99 хүүхдийг дархлаажуулаад байна.


02 сарын 18-ны өдөр байгууллагын нийт ажилчид 2/2-роо 2-4 цагийн хугацаанд сумын төв үйлчилгээний газрууд болон төмөр замын гарманд постонд гарч эргүүл хяналтыг хийж ажилласан байна.



2021 ны 02 сарын 19-ний өдөр байгууллагын хуваарьт талбайд их цэвэрлэгээг хийж ажилласан байна. Тус цэвэрлэгээнд нийт 12 ажилтан цэвэрлэгээнд гарч ажилласан байна.



02 сарын 22-ны өдөр Монголын сумдын эмч нарын холбооноос зохион байгуулсан Сүрээгийн тандал судалгаа сургалтанд хамрагдсан байна.



Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүд "Ковид-19-ын эсрэг вакцинжуулалтыг зохион байгуулах нь" сэдэвт сургалтанд хамрагдаж байна.



02 сарын 23-ны өдөр төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Ёс зүйн сургалтанд байгууллагын ёс зүйн баг ажилчидын хамт хамрагдсан байна.



Коронавирусын халдвараас сэргийлэх дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах байрыг бэлтгэн ажиллаж байна.



МАЛ ЭМНЭЛЭГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГ

Суманд отроор 24 малчин өрхийн 444 бод, 15171 бог нийт 15615 толгой мал өвөлжиж байна. Гадны аймаг сумдад 16 өрхийн 9040 толгой мал оторлож байснаас сумандаа 4 өрхийн 2506 толгой мал ирсэн байна.

Шивээговь сумын том малын зүй бус хорогдол нийт 813 үүнээс адуу-8, үхэр-4, хонь-315, ямаа-486 байна.

Хүнсний нөөцийн судалгааг нийт 9 дэлгүүр, 1 махны лангуу, 1 усны үйлдвэрээс өдөр бүр авч нэгтгэн аймгийн ХААГ-т болон сумын шуурхай штабт гарган өгч байна. Шивээговь сумын аюулгүйн нөөцөд 20 боодол өвс байна. 1 боодол өвсийг 10000-р Аймгийн аюулгүйн нөөцөөс 1331 боодол өвс татсан 1 боодол өвсийг 7000-р худалдаалж байна. Үүнээс 10 өрхөд 70 боодол боодол өвс зарсан. Үлдэгдэл 1261 боодол өвс байна



НИЙГМИЙН БОДЛОГО

Гэр бүлийн хүчирхийлэлийн 3 Кейс нээн ажиллаа. Үндэсний хөтөлбөрийн сумын зөвлөлийн захирамж шинэчлэн гаргаж байгуулга аж ахуй нэгжүүд Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол бичгийн хичээлийг сурах ажлыг эхлүүлээд байна.

Хувь хүний ур чадварыг дээшлүүлэх Энтерпренершипт төсөлд хамрагдах 14-25 насны 20 ш залуучууд, ЕБС-н 8-12 ангийн 48 сурагчийг сонгон шалгарууллаа.

Иргэдээс 1 эмчилгээний зардал хүссэн өргөдөл 1 хүүхэд үрчлэх өргөдөл 3 харгалзан дэмжигч тогтоолгох өргөдөл ирсэнийг ажлын хэсгээр хэлэлцүүлж шийдвэрлэж өглөө.

Сумын хэмжээнд нийт 296 ахмад настнаас 251 ахмад настан буюу 84,8 хувийг суманд үйл ажиллагаа явуулдаг 40 аж ахуйн нэгж, байгууллагад харьяалуулж, харьяалалгүй 45 ахмад настныг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хүндэтгэлд хамруулаад байна. Аймгийн ГБХЗТөвтэй хамтарч эрсдэлд нэн түрүүн өртөж болзошгүй 5 хүүхдийг эрсдлээс сэргийлэх даатгалд хамрууллаа.

БАЙГАЛЬ ОРЧИН

Бүх нийтийн цэвэрлэгээг 02 сарын 08, 19 –ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулан, сумын төвийн ногоон байгууламжийн хашааг засах босгох ажлыг албан байгууллага аж ахуй нэгжээр хийлгэсэн. Нийт 8 га талбайн 5,8 тн хог хаягдалыг 24 аж ахуй нэгжийн 67 ажилтан албан хаагчид 31 иргэн цэвэрлэгээнд хамрагдаж, төв хогийн цэгт зөөж тээвэрлэсэн. Хог тээвэрлэлт хуваарийн дагуу хэвийн явагдаж байна

Малчин айл өрхөөр орох, сэг зэм устгах ажлыг 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдөр засаг даргын удирдамжийн дагуу Хаялага нуур, 21-р зөрлөг, 22-р зөрлөг, Шивээговь сум маршрутаар сэг зэм устгалын ажлыг нийт 310 гаруй километр явж, 4 адуу, 6 үхэр, 20 зээр, 4 дугуй, түр буудаллах цэгийн хог хаягдлыг тээвэрлэн төв хогийн цэгт булаж устгах ажлыг зохион байгуулан ажиллаа

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН

1. Шивээговь сумын хүнсний нөөцийн судалгааг нийт 10 дэлгүүр, 1 махны лангуу, 1 усны үйлдвэрээс тус тус авч аймгийн ХААГ-т болон сумын онцгой байдлын шуурхай штабт өдөр бүр гаргаж өгч ажиллалаа.
2. Сум хөгжүүлэх сангийн 2020 оны жилийн эцсийн тайланг цахимаар болон бичгээр гаргаж хүргүүллээ.
3. Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас ирүүлсэн албан тоотын хариуг илгээлээ.
4. Сумын сайн малчин тодруулах үйл ажиллагааны туслах ажилд оролцсон.
5. Сар шинийн баяраар сумын ЗДТГ-н ажилчид цагийн хуваарийн дагуу эргүүлд гарсан.
6. Сумын гадаа хог цэвэрлэх ажилд оролцсон.
7. Сумын онцгой комиссын шуурхай штабд 24 цагийн хариуцлагатай жижүүрт гарсан.
8. Сум хөгжүүлэх сангийн 2 сарын мэдээг аймаг руу илгээсэн.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

| Хийгдсэн ажил | Он сар | Мөнгөн дүн | Тайлбар |
|---|------------|-------------|---|
| 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих "Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах" ажлын хэсэг байгуулах тухай захирамж | 2021.02.08 | - | Засаг даргын захирамж № А/16 |
| Шивээговь суманд 2021 онд хэрэгжүүлэх барилга бйагууламжийн угсралт, засварын ажилд захиалагчийн хяналт хийлгэх гэрээг байгуулсан | 2021.02.15 | 134 000 000 | Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын дарга |
| Шилэн дансны мэдээлэл оруулсан | 2021.02.08 | | Хөрөнгө болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл |
| Шилэн дансны мэдээлэл оруулсан | 2021.02.08 | | ХАА-нд хийсэн Аудит тайлан дүгнэлт болон бусад хяналт шалгалт дүгнэлт |

| | | | | |
|--|------------|-----|-------|--|
| Шилэн дансны мэдээлэл оруулсан | 2021.02.08 | | | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншэлийн гэрээ концес төлөвлөгөө, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр |
| “Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах” ажлын даалгаварыг бэлдэхтэй холбоотой ажлын тоо хэмжээг батлагдсан төсөвт өртөгт тааруулан ирүүлэх албан тоот хүргүүлэв | 2021.02.05 | 000 | 5 000 | Шивээговь сумын Цагдаагийн хэсэгт |
| “Орон сууцны 3,6,7,8-р байрны хаалга шинэчлэх” ажлын хаалганы загварын судалгааг бэлдэв | 2021.02.10 | | | Засаг даргын Орлогчид танилцуулав |

МЭДЭЭ ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

Д. СУВД ЭРДЭНЭ